



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/187

Өмнөдэлгэр сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дахь заалт, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний 10 дугаар тогтоол, Засгийн газрын 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 45 дугаар тогтоол, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн 2025 оны 12 дүгээр сарын 17-ний өдрийн 33 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2026 оны сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 4977721 төлөвлөлтийн нэгж талбарын дугаартай, зарлагдсан дуудлага худалдааны ялагч болсон Жанцангийн Мөнхзул (CP80051404)-д тус сумын 6 дугаар баг, Булган гудамжинд зочид буудлын зориулалтаар 2878м² газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших гэрээг жил бүр дүгнүүлж, газрын төлбөрийг хугацаанд нь төлж, Газрын тухай хууль болон гэрээний дагуу эзэмшихийг газар эзэмшигч (Жанцангийн Мөнхзул)-т даалгасугай.

3. Газар эзэмшилтэнд байнгын хяналт тавьж, газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг сумын Газрын даамал (Ё.Мөнх-Өлзий)-д үүрэг болгосугай.



Р.ЭНХТӨР